



**МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 07 сарын 05 өдөр


Дугаар 8/436

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 7/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчид болон бүтээн байгуулалтын талаар нэвтрүүлэг бэлтгэх дэмжлэг үзүүлэх зорилгоор 1 111 000 төгрөгийг зарцуулсугай.
2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 1 111 000 төгрөг (нэг сая нэг зуун арван нэгэн мянга)-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 7/02 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 4.8-д тусгагдсан “Үйлдвэрлэгч Ховд” хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх) нарт зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Дэлгэрсайхан)-д даалгасугай.



Б.ДҮГЭРЖАВ